

Улсын бүртгэлийн
дугаар
Аравтын бүрэн
ангиллын код

Нууцын зэрэглэл: Б

Төсөл хэрэгжүүлэх
гэрээний дугаар ШуСс-2018/38

МУИС-ИЙН ТҮҮХИЙН ТЭНХИМ

“НЭГДЭЛЧ МАЛЧДЫН ТҮҮХИЙГ ШИНЭЭР ЭРГЭН ХАРАХУЙ”

Шинжлэх ухаан технологийн сангийн суурь судалгааны төслийн тайлан

(2018-2022)

Төслийн гүйцэтгэгч байгууллага:
Төслийн удирдагч:

МУИС-ийн Түүхийн тэнхим
П.Дэлгэржаргал – МУИС-ийн
Түүхийн профессор, доктор

Санхүүжүүлэгч байгууллага:

Шинжлэх ухаан технологийн сан

Захиалагч байгууллага:

БШУЯ

Тайланг өмчлөгч байгууллага:

МУИС-ийн Түүхийн тэнхим

Улаанбаатар, 2023

Улсын бүртгэлийн
дугаар
Аравтын бүрэн
ангиллын код

Нууцын зэрэглэл: Б
Төсөл хэрэгжүүлэх
гэрээний дугаар ШуСс-2018/38

МУИС-ИЙН ТҮҮХИЙН ТЭНХИМ

“НЭГДЭЛЧ МАЛЧДЫН ТҮҮХИЙГ ШИНЭЭР ЭРГЭН ХАРАХУЙ”

Шинжлэх ухаан технологийн сангийн суурь судалгааны төслийн тайлан

(2018-2022)

Төслийн гүйцэтгэгч байгууллага:
Төслийн удирдагч:

МУИС-ийн Түүхийн тэнхим
П.Дэлгэржаргал – МУИС-ийн
Түүхийн профессор, доктор

Гарын үсэг

Санхүүжүүлэгч байгууллага:

Шинжлэх ухаан технологийн сан

Захиалагч байгууллага:

БШУЯ

Тайланг өмчлөгч байгууллага:

МУИС-ийн Түүхийн тэнхим

Улаанбаатар, 2023

ТӨСЛИЙН УДИРДАГЧ:

МУИС-ИЙН ТҮҮХИЙН ТЭНХИМИЙН
ПРОФЕССОР П.ДЭЛГЭРЖАРГАЛ

ТӨСЛИЙН ГҮЙЦЭТГЭГЧ:

МУИС-ИЙН ШУС-ИЙН ХҮМҮҮНЛЭГИЙН
УХААНЫ САЛБАРЫН ЗАХИРАЛ,
ДОКТОР Н.АЛТАНТӨГС

ШУА-ИЙН ОЛОН УЛСЫН ХАРИЛЦААНЫ
ХҮРЭЭЛЭНГИЙН ЭРДЭМТЭН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА, ДОКТОР Р.ТӨРДАЛАЙ

МУИС-ИЙН ШУС-ИЙН ТҮҮХИЙН
ТЭНХИМИЙН ЭРХЛЭГЧ, ДОКТОР
Б.ЧИНЗОРИГ

ГАРЧИГ

Нэг. Судалгааны үндэслэл	4
Хоёр. Судалгааны ажлын үе шат	5
Гурав. Сэдэвт ажлын эцсийн үр дүн	7
3.1. Хээрийн судалгааны тайлан	7
3.2. Төслийн судалгааны үр дүн	18
Дөрөв. Бүтээлийн тодорхойлолт	20
4.1. Нэгэн сэдэвт бүтээл: Сум нэгдлийн тогтолцоо (малчин өрх-нэгдэл-улс)..	20
4.2. Эрдэм шинжилгээний өгүүлэл	23
4.2.1. Р.Төрдалай. Монгол дахь хамтралжуулалт ба ЗХУ-ын нөлөөллийг эргэн харах нь	23
4.2.2. Н.Алтантөгс. Хөдөө аж ахуйн нэгдлийн мал аж ахуйн таваарын бүтээгдэхүүний борлуулалт, хэрэглээ (1960-1990)	24
4.2.3. Н.Алтантөгс, П.Дэлгэржаргал. БНМАУ-ын сум нэгдлийн тогтолцоо	24
4.2.4. Б.Чинзориг. Ардын аж ахуйтныг хоршоолсон нь (1958-1959): түүх бичлэг ба бодит байдал (Архангай аймгийн жишээн дээр)	25
4.2.5. Р.Төрдалай. Сум-нэгдлийн газрын асуудал ба засаг захиргааны өөрчлөлт (1960-1990-ээд он)	25
4.2.6. N.Altantugs, P.Delgerjargal. “Soum negdel” Agricultural and Administration System in Mongolia. <i>Oriental Studies</i> . Scopus ID: 21100927989. 2023.	26
4.2.7. Turdalai Radnaased. Mongolian’s Administrative Division during the Formation of Agricultural Associations (1935-1959): the Impact of Land and Pasture Issues. <i>Oriental Studies</i> , 2019. Is. 2.	27
Тав. Судалгааны шинэлэг тал	28
Зургаа. Нийгэм эдийн засгийн ач холбогдол	29
Долоо. Хавсралт	31

“Нэгдэлч малчдын түүхийг шинээр эргэн харахуй” суурь судалгааны төсөл

Шинжлэх ухаан технологийн сангийн 2018 оны суурь судалгааны төслийн сонгон шалгаруулалтад МУИС-ийн Түүхийн тэнхимээс “Нэгдэлч малчдын түүхийг шинээр эргэн харахуй” төслийг дэвшүүлж сонгон шалгаруулалтад оролцсон. Уг төсөл сонгон шалгаруулалтаар дэмжигдэж 2018 оны 5 дугаар сарын 10-ны тушаалыг үндэслэн ШУТСантай ШУСс-2018/38 тоот гэрээ байгуулан ажилласан.

НЭГ. СУДАЛГААНЫ ҮНДЭСЛЭЛ

Монголын мал аж ахуй түүхэнд анх удаа XX зууны дунд үед өмчийн хэлбэр өөрчлөгдөж малыг нийгэмчилсэн явдал бол олон мянганаар уламжилж ирсэн малчдын амьдралын тогтсон зохион байгуулалтыг өөрчилж, мал аж ахуйд чанарын шинэчлэл гаргасан томоохон үйл явдал байсан билээ.

1960-1990 онд БНМАУ-д оршиж тогтнож байсан сум нэгдлийн тогтолцоо нь ХААН ба засаг захиргааны үндсэн нэгж болох сум хоёр албан ёсоор тусдаа бүтэц боловч бодит амьдрал дээр энэ бүтэц хэрхэн ажилладаг байсныг судлан тодруулах зайлшгүй шаардлага байсаар байна.

Өнөөг хүртэл социалист Монгол орны нэгдэлч малчдын түүхийг нэг талаас ерөнхий, нөгөө талаар үзэл сурталжсан өнцгөөс харж судалсаар иржээ. Бидний судалгааны үндсэн зорилго Монгол орны эдийн засгийн цөмийг бүрдүүлж ирсэн мал аж ахуйн салбарын түүхийг 1935-1990 онд Монголд оршин тогтносон хөдөө аж ахуйн нэгдэл, нэгдэлч малчдын амьдралын түүхэнд суурилуулан судалж, дүн шинжилгээ хийхэд чиглэгдэж байна.

Мал аж ахуйн түүхий эдийг бэлтгэл улсын бэлтгэлийн систем нь дотоодын үйлдвэрүүд болон ЗХУ-д гаргах хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний экспортын хямд түүхий эд бэлтгэхэд гүйцэтгэсэн үүргийг тодруулах нь сум-нэгдлийн тогтолцоог байгуулсан зорилгыг ойлгоход түлхүүр ач холбогдолтой байж болох юм.

Нэгдлийн түүхийг **малчин өрх - нэгдэл - улс** гэсэн гурван түвшинд судалгааны шинэлэг арга зүйгээр судалж, социализмын үеийн нэгдлийн түүхийг нэгтгэн дүгнэж, одоогийн мал аж ахуйн цаашдын хөгжлийн арга замыг тодорхойлох шаардлага тулгамдсан асуудал болж байна. Түүнчлэн ХАА-н нэгдлийн гишүүдийн аман яриаг аман түүхийн орчин

үеийн арга зүйн дагуу дуу, дүрсээр бичин авч үлдэн, цаашдын судалгааны бааз, мэдээллийн сан үүсгэх шаардлага тавигдаж байгаа билээ.

ХОЁР. ТӨСЛИЙН ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ҮЕ

Судалгааны ажил хэд хэдэн үе шат бүхий төлөвлөгөөний дагуу хэрэгжсэн. Үүнд,

1. Аман түүхийн болон архивын баримт, сурвалж, судалгааны бааз бүрдүүлэх.

1.Дотоодын архив. МУҮТА, Улс төр олон нийтийн байгууллагын баримтын архив, Гадаад хэргийн архив, Архангай аймгийн архив, Төв аймгийн архив, ҮНС зэрэг газруудад ажиллаж, бичгийн болон аман эх сурвалж, баримт цуглуулж, задлан шинжилгээ хийв. Товч тэмдэглэл үйлдсэн болон төлбөртэйгөөр хуулбарлаж авсан МУҮТА-ын баримтын жагсаалтыг явцын тайланд хавсаргаж өгсөн болно.

2. Гадаад дахь архивын судалгаа.

Төслийн багийн гишүүн Н.Алтантөгс МУИС-ийн захирлын 2020 оны 1-р сарын 16-ны А/20 дугаар тушаалаар төслийн судлаач Н.Алтантөгс ОХУ-ын Улаан-Үд хотод байрлах Буриадын Улсын Архивт (Государственный архив Республики Бурятия - ГАРБ) 2020 оны 1-р сарын 18-наас 1-р сарын 26-ны хооронд томилолтоор ажиллав.

Тус томилолтын ажлаар Буриадын Улсын Архивт хадгалагдаж буй БНМАУ-аас ЗХУ-д нийлүүлсэн хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнтэй холбогдох архивын баримт, материал илрүүлж, хуулбарлан авах зорилт тавьсан юм. Ажиллах явцад БНМАУ-аас ЗХУ руу мал импортлох ажлын гол чиглэлийг хариуцаж байсан ЗХУ-ын “Скотоимпорт” нэгдлийн Улаан-Үд дэх конторын Буриадын Улсын Архив дахь “р-662” хөмрөгийн баримтуудтай танилцаж, 15 хадгаламжийн нэгжээс 159 хуудас баримтыг судалгааны эх хэрэглэгдэхүүн болгон хуулбарлан авав

2. Хээрийн судалгаа хийх. 2018, 2019, 2022 онуудад хээрийн судалгаа хийсэн. Үүнд, -2018 оны 7.26-8.16-нд 21 хоногийн хугацаанд Хөвсгөл аймгийн Мөрөн хот, Тосонцэнгэл сум, Архангай аймгийн Цэцэрлэг хот, Ихтамир сумдад хээрийн судалгаа хийж, нэгдлийн түүхэнд холбогдох 61 х.х архивын баримт, 18 цагийн аман түүхийн бичлэг, 11 ном сурвалж бүрдүүлэв.

Маршрут: Улаанбаатар (VII.25) → (VII.26) Хөвсгөл аймгийн Мөрөн хот (VII.28) → (VII.28) Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын төв (VII.31) → (VIII.1) Улаанбаатар (VIII.2)

→ (VIII.2) Архангай аймгийн Цэцэрлэг хот (VIII.10) → (VIII.10) Архангай аймгийн Ихтамир сум (VIII.15) → (VIII.16) Улаанбаатар.

-2019 онд төслийн баг төслийн төлөвлөгөөнд заасны дагуу нэгдлийн түүхэнд холбогдох аман түүхийн судалгааны томилолтоор 2019 оны 6-р сарын 15-наас 7-р сарын 23-ны хооронд 39 хоногийн хугацаанд Хөвсгөл, Архангай, Хэнтий аймгийн зарим газарт судалгаа явуулав.

Тус томилолтын ажлаар орон нутагт хадгалагдаж буй нэгдлийн түүхэнд холбогдох архивын баримт, материал илрүүлж, судалгааны материал бүрдүүлэх, нэгдлийн түүхэнд холбогдох амьд гэрч нараас ярилцлага авч, аман түүхийн мэдээллийн сан үүсгэх, орон нутгийн түүхийн судалгааны ном, бүтээлтэй танилцах зорилт тавив.

Маришрут: Улаанбаатар (VI.15) → Архангай аймгийн Цэцэрлэг хот (VI.15) → Архангай аймгийн Ихтамир сум (VI.18) → Архангай аймгийн Цэцэрлэг хот (VI.29) → Улаанбаатар (VII.5) → Хэнтий аймгийн Чингис хот (VII.7) → Улаанбаатар (VII.10) → Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын төв (VII.15) → Хөвсгөл аймгийн Мөрөн хот (VII.18) → Улаанбаатар (VII.24)

Төслийн ажлын төлөвлөгөөгөөр 2021 оны 7-8 сард хээрийн судалгаа хийж, Архангай аймгийн болон Гэрэлт зам нэгдлийн архивын суух, нэгдэлд ажиллаж байсан малчид, албан хаагчидтай уулзаж ярилцлага авч, аман түүхийн санд оруулах ажлыг хийх ёстой байв. Гэвч ковид цар тахлын улмаас хөдөө хээрийн судалгаа хийх боломжгүй болж, уг хээрийн судалгааны ажлыг 2022 оны 3 болон 7-8 дугаар сард хийж гүйцэтгэсэн болно.

3. Судалгааны үзэл баримтлал боловсруулах. Төслийн хүрээнд цуврал хэлэлцүүлэг зохион байгуулж, нэгэн сэдэвт зохиолын үзэл баримтлал, бүтцийг хэлэлцэн батлах, сайжруулах ажлыг хийсэн. Түүнчлэн төслийн хүрээнд бичигдэж байгаа өгүүллүүдийг хэлэлцэн сайжруулах ажилд ихээхэн анхаарал хандуулсан болно.

2021 онд Үндсэний музейтэй хамтран “Нэгдэлч малчдын түүхийг шинээр эргэн харахуй” сэдэвт эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулж, хэлэлцүүлэг хийсэн нь судалгааны ажлыг сайжруулахад чухал үүрэгтэй олсон билээ.

2021-2022 онд “Сум нэгдлийн тогтолцоо” нэгэн сэдэвт зохиолын хэлэлцүүлгийн хэд хэдэн удаа зохион байгуулж, зохиогчдын бичсэн бүлэг зүйлүүдийг хэлэлцэв. 2022 онд “Сум

нэгдлийн тогтолцоо” нэгэн сэдэвт бүтээлийг бичиж дуусган редакторлаж, хэвлэн гаргаж нийтийн хүртээл болгов.

ГУРАВ. СЭДЭВТ АЖЛЫН ЭЦСИЙН ҮР ДҮН

3.1. Төслийн хээрийн тайлан (2018-2022 он)

Тус төслийн хүрээнд 2018, 2019, 2020, 2022 онуудад хээрийн судалгааны ажлуудыг Хөвсгөл аймгийн Мөрөн хот, Тосонцэнгэл сум, Архангай аймгийн Цэцэрлэг хот, Ихтамир сум, Баянхонгор аймгийн Галуут сум, мөн ОХУ-ын Улаан-Үд хотод орших Буриадын Улсын Архивт (Государственный архив Республики Бурятия-ГАРБ) гүйцэтгэв. Хээрийн судалгаануудыг гурван үндсэн чиглэлээр гүйцэтгэсэн. Үүнд:

1. Аман түүх
2. Архивын судалгаа
3. Баримт мэдээллийн сан бүрдүүлэлт зэрэг болно.

1. АМАН ТҮҮХИЙН СУДАЛГАА

Архангай аймгийн Цэцэрлэг хот, Ихтамир суманд 2018, 2019 онд, Хөвсгөл аймгийн Мөрөн хот, Тосонцэнгэл суманд 2019 онд, 2022 онд Баянхонгор аймгийн Галуут сумдад амьдарч буй өндөр настнуудын дунд судалгаа явуулж, нийт 35 хүнтэй дэлгэрэнгүй ярилцлага хийв. Аман түүхийн судлагааг хийхийн тулд урьдчилсан уулзалт, ярилцлага хийж, уулзалтын яриаг гэрэл зураг, дуу авиа болон дүрс бичлэгээр баримтжуулан хадгалж, судалгааны сан үүсгэсэн болно.

2018-2022 онд явуулсан аман түүхийн судалгаанд нэгдлийн дарга 2, нэгдэл дундын үйлдвэрийн дарга 1, нэгдлийн зөвлөлийн удирдах албаны хүн 2, нэгдлийн мэргэжилтэн хүн 7 хамрагдсан (Хүснэгт 1, Хавсралтыг үзнэ үү).

Хүснэгт 1.

Аман түүхийн судалгаанд хамрагдсан ярилцагчдын жагсаалт

	Нэр, овог	Аймаг, сум-нэгдэл	Эрхэлж байсан ажил, албан тушаал	Он
1	Лонжидсүрэн, Д.	Архангай аймаг, Ихтамир сум	“Гэрэлт зам” нэгдлийн дарга	2018

2	Дамдинсүрэн, З.	Архангай аймаг, Ихтамир сум	“Гэрэлт зам” нэгдлийн орлогч дарга	2018
3	Дагдан, Д.	Архангай аймаг	НДҮ-ийн дарга	2018
4	Пүрэвдорж, С.	Архангай аймаг	Нэгдлийн зөвлөлийн дарга	2018
5	Ядамсүрэн, Т.	Архангай аймаг	Нэгдлийн зөвлөлийн боловсон хүчний дарга	2018
6	Бадарч, Г.	Архангай аймаг, Ихтамир сум	“Гэрэлт зам” нэгдлийн боловсон хүчний дарга	2018
7	Дашзэвэг, Ж.	Архангай аймаг, Ихтамир сум	“Гэрэлт зам” нэгдлийн зоотехникч	2018
8	Данаа, Р.	Архангай аймаг, Ихтамир сум	“Гэрэлт зам” нэгдлийн зоотехникч	2018
9	Лхагважав, Н.	Архангай аймаг, Ихтамир сум	“Гэрэлт зам” нэгдлийн мал хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, ботаникч	2018
10	Баяраа, Ш.	Баянхонгор аймаг, Баянлиг сум	“Ленинч” нэгдлийн нягтлан бодогч	2019
11	Жамц, Д.	Хөвсгөл аймаг, Тосонцэнгэл сум	“Ардын зориг” нэгдлийн нягтлан бодогч	2019
12	Батмөнх, Ч.	Хөвсгөл аймаг, Тосонцэнгэл сум	“Ардын зориг” нэгдлийн фермийн дарга	2019
13	Сэмидпэрлээ, Н.	Архангай аймаг	“Гэрэлт зам” нэгдлийн багийн дарга, Аймгийн усны удирдах газрын гидротехникч	2019
14	Бадамдорж, Д.	Хөвсгөл аймаг, Тосонцэнгэл сум	“Ардын зориг” нэгдлийн агент	2019
15	Лхагваа, Д.	Хөвсгөл аймаг, Тосонцэнгэл сум	“Ардын зориг” нэгдлийн сүүний заводын ажилчин	2019
16	Нямдорж, Ш.	Хөвсгөл аймаг, Тосонцэнгэл сум	“Ардын зориг” нэгдлийн механикч, тракторч	2019

17	Сүхдалай, Н.	Хөвсгөл аймаг, Тосонцэнгэл сум	“Ардын зориг” нэгдлийн ногоочин	2019
18	Төмөрбүргэд, Д.	Архангай аймаг, Ихтамир сум	"Гэрэлт зам" нэгдлийн малчин	2019
19	Төмөрчөдөр, Б.	Архангай аймаг, Ихтамир сум	“Гэрэлт зам” нэгдлийн малчин	2019
20	Хонинхүү, Д.	Хөвсгөл аймаг, Тосонцэнгэл сум	“Ардын зориг” нэгдлийн малчин	2019
21	Сэсэм, Х.	Хөвсгөл аймаг, Тосонцэнгэл сум	“Ардын зориг” нэгдлийн малчин, тууварчин	2019
22	Эрдэнэдаваа, М.	Хөвсгөл аймаг, Тосонцэнгэл сум	“Ардын зориг” нэгдлийн малчин	2019
23	Даваахүү, С.	Хөвсгөл аймаг, Тосонцэнгэл сум	“Ардын зориг” нэгдлийн малчин	2019
24	Сандагаа, П.	Хөвсгөл аймаг, Тосонцэнгэл сум	“Ардын зориг” нэгдлийн малчин	2019
25	Цэнд-Аюуш, Д.	Хөвсгөл аймаг, Тосонцэнгэл сум	“Ардын зориг” нэгдлийн малчин	2019
26	Ганболд, Б.	Хөвсгөл аймаг, Тосонцэнгэл сум	“Ардын зориг” нэгдлийн малчин, тууварчин	2019
27	Жилийсэн, Н.	Архангай аймаг, Ихтамир сум	“Гэрэлт зам” нэгдлийн саальчин	2019
28	Мөнгөнцэцэг, П.	Архангай аймаг, Ихтамир сум	“Гэрэлт зам” нэгдлийн саальчин	2019
29	Хишиг-Уул, М.	Архангай аймаг, Ихтамир сум	“Гэрэлт зам” нэгдлийн саальчин	2019
30	Бямбаа, Д.	Архангай аймаг, Ихтамир сум	“Гэрэлт зам” нэгдлийн саальчин	2019
31	Баасандолгор, Ч.	Архангай аймаг, Ихтамир сум	“Гэрэлт зам” нэгдлийн саальчин	2019
32	Алагаа, Д.	Хөвсгөл аймаг, Тосонцэнгэл сум	“Ардын зориг” нэгдлийн саальчин	2019

33	Наранцэцэг, Л.	Хөвсгөл аймаг, Тосонцэнгэл сум	“Ардын зориг” нэгдлийн саальчин	2019
34	Нацаг-Юм, М.	Архангай аймаг, Чулуут сум	Сумын сургуулийн захирал	2019
35	Мягмарсүрэн, П.	Хөвсгөл аймаг	Эг-үүрийн САА-н кино механикч	2019

Аман түүхийн эхийг CD-д бичиж хавсаргав.

Нэгдлийн тухай аман түүхийн судалгаа хийснээр хөдөө аж ахуйн нэгдэл тарах үед холбогдох нэгдлийн дарга нарын үйл ажиллагаа, нэгдлийг тараасан процесс, нэгдлийн санхүү, орлого зарлага, мал аж ахуйн үйл ажиллагаа, тэдгээрийн талаар хэвлэгдэн гарсан ном, судалгаа зэрэг мэдээллийг нэгдэлд хариуцлагатай алба хашиж байсан амьд гэрч нарын яриагаар бүрдүүлж, судалгаанд ашиглах боломж нээгдэв. Мөн тус төслийн судалгааны хүрээнд хөдөө аж ахуйн нэгдлийн малчид, хоньчин, үхэрчин, адуучин, саальчин, тэмээчин зэрэг ажилчдын аман түүхийн талаар тусгайлан анхаарч судалсан.

2. АРХИВЫН СУРВАЛЖИЙН СУДАЛГАА

А. Гадаадын архивын судалгаа.

Төслийн багийн гишүүн Н.Алтантөгс ОХУ-ын Улаан-Үд хотод байрлах Буриадын Улсын Архивт (Государственный архив Республики Бурятия - ГАРБ) 2020 оны 1-р сарын 18-наас 1-р сарын 26-ны хооронд томилолтоор ажиллав. ОХУ-ын Буриадын архиваас БНМАУ-аас ЗХУ-д экспортолж байсан мал аж ахуйн бүтээгдэхүүнтэй холбоотой архивын баримт олж илрүүлэх нь манай судалгааны онцгой ач холбогдолтой юм.

Тус томилолтын ажлаар Буриадын Улсын Архивт хадгалагдаж буй БНМАУ-аас ЗХУ-д нийлүүлсэн хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнтэй холбогдох архивын баримт, материал илрүүлж, хуулбарлан авах зорилт тавьсан юм. Ажиллах явцад БНМАУ-аас ЗХУ руу мал импортлох ажлын гол чиглэлийг хариуцаж байсан ЗХУ-ын “Скотоимпорт” нэгдлийн Улаан-Үд дэх конторын Буриадын Улсын Архив дахь “р-662” хөмрөгийн баримтуудтай танилцаж, 15 хадгаламжийн нэгжээс 159 хуудас баримтыг судалгааны эх хэрэглэгдэхүүн болгон хуулбарлан авав (Хүснэгт 2-ыг үзнэ үү).

ОХУ-ын Улаан-Үд хотод байрлах Буриадын Улсын Архиваас (Государственный архив Республики Бурятия - ГАРБ) хуулбарлан авсан 159 хуудас баримтын жагсаалтыг Хүснэгт 2-т харуулав:

Хүснэгт 2.

**ОХУ-ын Буриадын Улсын Архиваас (ГАРБ)
хуулбарлан авсан баримтуудын жагсаалт**

№	Архив зүйн шифр	Агуулга	Хугацаа	Хуудасны тоо
1	Ф. р-662, оп. 1, д. 335.	“Скотоимпорт” нэгдлийн Улаан-Үдийн конторын 1952-1962 оны үйлдвэрлэл-санхүүгийн үйл ажиллагааны тайлан зэрэг баримтууд	1962-1963	25
2	Ф. Р-662, оп. 1, д. 276.	“Скотоимпорт” нэгдлийн тушаал зэрэг баримтууд	1959-1960	24
3	Ф. Р-662, оп. 1, д. 303.	“Скотоимпорт” нэгдлийн Наушки баазын 1967 оны тайлан	1967	15
4	Ф. Р-662, оп. 1, д. 84.	Тууврын сүргийн бүртгэлийн дэвтэр	1937	6
5	Ф. Р-662, оп. 1, д. 279.	БНМАУ-аас мал импортлох үнэ, тоо хэмжээ, тууврын чиглэл зэрэг баримтууд	1960	11
6	Ф. Р-662, оп. 1, д. 287.	“Скотоимпорт” нэгдлийн Улаан-Үдийн конторын тайлан балансын хурлын тэмдэглэл	1963	3
7	Ф. Р-662, оп. 1, д. 121.	Мал усан замаар тээвэрлэх тухай гэрээ	1938	3
8	Ф. Р-662, оп. 1, д. 365.	“Скотоимпорт” нэгдлийн Улаан-Үдийн контороос махны гарцын тухай бичсэн захидал	1969	4
9	Ф. Р-662, оп. 1, д. 363.	“Скотоимпорт” нэгдлээс Улаан-Үдийн конторт ирүүлсэн даалгавар, төлөвлөгөө	1968	10

10	Ф. Р-662, оп. 1, д. 377.	“Скотоимпорт” нэгдлээс Улаан-Үдийн конторт ирүүлсэн албан бичиг	1968	1
11	Ф. Р-662, оп. 1, д. 425.	БНМАУ дахь ЗХУ-ын худалдааны төлөөлөгч Л.Г.Аваков болон “Скотоимпорт” нэгдлийн дарга А.П.Шилин нарын уулзалтын тэмдэглэл	1972	3
12	Ф. Р-662, оп. 1, д. 498.	“Скотоимпорт” нэгдлийн харьяа конторуудын төлөвлөгөөний биелэлтийн мэдээ	1977	17
13	Ф. Р-662, оп. 1, д. 309.	“Цагаан-Арал” дамжлага баазын ажлын тухай тайлан	1968	21
14	Ф. Р-662, оп. 1, д. 549.	Улаан-Үдийн конторын 1980 оны үйлдвэрлэлийн нийт зардлын тайлан	1980	1
15	Ф. р-662, оп.-1, д. 121.	Мал худалдах тухай Монгол-Зөвлөлтийн байгууллага хоорондын гэрээ	1938	15
	Нийт			159

Б. Дотоодын архивын судалгаа.

Төслийн багийн гишүүд Архангай аймгийн Тамгын газрын харьяаны архивын газар 2018, 2019, 2022 онд нэгдлийн түүхэнд холбогдох сурвалж, баримтын судалгаа хийв. Судалгааны үр дүнд Архангай аймгийн Ихтамир сумын “Гэрэлт зам”, Жаргалант сумын “Жаргалант амьдрал” нэгдэл, “Ялалт”, “Бадрал”, “Ардын зориг”, “Чөлөөт Амьдрал”, “Хөдөлмөрч”, “Пионерийн зам”, “Социализмын зам”, “Цацрал”, “Туяа”, “Өрнөл”, “Улаан туг”, “Их – Эхлэлт” нэгдлүүдийн болон тус аймгийн Нэгдлийн зөвлөл, АДХ, МАХН-ын хороо, Ардын хянан шалгах, шүүх, прокурорын байгууллагын хөмрөг, дансанд хадгалагдаж буй нэгдлийн түүхэнд холбогдох 250 гаруй хадгаламжийн нэгж, 50 гаруй х.х материалтай танилцаж судалгааны тэмдэглэл үйлдэв (Хүснэгт 3-ыг үзнэ үү).

Хүснэгт 3.

Архангай аймгийн Ихтамир сумын “Гэрэлт зам” нэгдлийн түүхэнд холбогдох архивын баримтын жагсаалт

	Хөмрөгийн дугаар	Хөмрөгийн нэр	Боловсруулалт
--	-------------------------	----------------------	----------------------

X 1, Д 2, Хн 144, 180, 188.	Архангай аймгийн архив. Аймгийн АДХГЗ.	
X 27, Д 1, Хн 2, 5, 6.	Архангай аймгийн архив. Жаргалант сумын “Жаргалант амьдрал” нэгдэл.	Тэмдэглэл үйлдэж, боловсруулсан.
X 29, Д 1, Хн 12.	Архангай аймгийн архив. Жаргалант сум.	Тэмдэглэл үйлдэж, боловсруулсан.
X 30, Д 1, Хн 74.	Архангай аймгийн архив. Их Тамир сум	Тэмдэглэл үйлдэж, боловсруулсан.
X 38, Д 1, Хн 14, 24, 26, 28, 29, 30, 31, 33, 38, 40, 41, 42, 43, 45, 46, 47, 53, 57, 60, 61, 64, 65.	Архангай аймгийн архив. Их Тамир сумын “Гэрэлт зам” нэгдэл	Тэмдэглэл үйлдэж, боловсруулсан.
X 38, Д 2, Хн 29, 62, 65, 71.	Архангай аймгийн архив. Их Тамир сумын “Гэрэлт зам” нэгдэл.	Тэмдэглэл үйлдэж, боловсруулсан.
X 60, Д 2, Хн 84, 88, 89, 94, 97, 108, 114, 115, 116, 118, 120, 121, 128, 132, 140, 142, 144, 145, 148, 149, 157, 158, 160	Архангай аймгийн архив. Их Тамир сумын “Гэрэлт зам” нэгдэл	Тэмдэглэл үйлдэж, боловсруулсан.
X 72, Д 1, Хн 2, 75	Архангай аймгийн архив. Аймгийн Нэгдлийн зөвлөл	Тэмдэглэл үйлдэж, боловсруулсан.
X 74, Д 1, Хн 235	Архангай аймгийн архив. Аймгийн Ардын хянан шалгах хороо	Тэмдэглэл үйлдэж, боловсруулсан.
X 78, Д 1, Хн 73, 74	Архангай аймгийн архив. Аймгийн Прокурорын газар	Тэмдэглэл үйлдэж, боловсруулсан.
X 86, Д 1, Хн 238, 239, 240	Архангай аймгийн архив. Аймгийн МХЗЭ	Тэмдэглэл үйлдэж, боловсруулсан.
X 109, Д 1, Хн 649, 673, 678, 717, 731, 732, 735	Архангай аймгийн архив. Аймгийн МАХН-ын хороо	Тэмдэглэл үйлдэж, боловсруулсан.

Тус томилолтын ажлаар орон нутагт хадгалагдаж буй нэгдлийн түүхэнд холбогдох архивын баримт, материал илрүүлж, судалгааны материал бүрдүүлэх, нэгдлийн түүхэнд холбогдох амьд гэрч нараас ярилцлага авч, аман түүхийн мэдээллийн сан үүсгэх, орон нутгийн түүхийн судалгааны ном, бүтээлтэй танилцах зорилт тавив.

Эдгээр баримтуудыг цуглуулж, тэмдэглэл үйлдсэнээр “Гэрэлт зам” нэгдлийн анх байгуулагдсан, нэгдлийн зөвлөлийн хурлын тэмдэглэл, орон тоо, төсвийн мэдээллүүд, үйл ажиллагааны төлөвлөгөө, жилийн тайлангууд, малын ба хүн амын тоо, түүний өөрчлөлт, тушаал шийдвэрүүд зэрэг олон талын эх сурвалжуудыг бүрдүүлэв.

Эдгээр баримтуудыг цуглуулж, тэмдэглэл үйлдсэнээр “Гэрэлт зам” нэгдлийн анх байгуулагдсан, нэгдлийн зөвлөлийн хурлын тэмдэглэл, орон тоо, төсвийн мэдээллүүд, үйл ажиллагааны төлөвлөгөө, жилийн тайлангууд, малын ба хүн амын тоо, түүний өөрчлөлт, тушаал шийдвэрүүд зэрэг олон талын эх сурвалжуудыг бүрдүүлэв.

3. БАРИМТ МЭДЭЭЛЭЛ, САН БҮРДҮҮЛЭЛТ

2018-2022 оны орон нутгууд дахь хээрийн судалгааны явцад сум-нэгдлийн түүхэнд холбогдох дараах 30 материал, ном, бүтээлүүдийг бүрдүүлж судалгаанд ашиглав. Үүнд:

1. Бидний бахархан дууриах хүмүүс, эрхэлсэн Ч.Тэрбиш, Н.Цанжид, Цэцэрлэг 1982.
2. Дурьдатгал-дурсамж, эмхэтгэсэн Ч.Тэрбиш, П.Товуу, Цэцэрлэг 1983.
3. Лонжидсүрэн, Д. Их Тамирынхан, Улаанбаатар: 2005.
4. Архангай Ихтамир дахь Нэгдэл дундын үйлдвэр, Тайхар 1975.
5. Даш, Д. Хан-өндөр уулын хошуу Ихтамир сум “Гэрэлт зам” нэгдэл, Цэцэрлэг 1970.
6. Дашзэвэг, О., Рэгсүрэн, Д. Тариат сум “Ялалт” нэгдэл, Цэцэрлэг: Архангайн үнэн сонины хэвлэх үйлдвэр 1976.
7. Галсанбаатар, Ш. Хайрхан сумын товч түүх, Улаанбаатар 2006.
8. Магсаржав, Х. Цэнхэр Сум “Социализмын зам” нэгдэл, Цэцэрлэг 1979.
9. Чулуутын голын цуурай, ред. С.Шархүү, Ж.Риймэд, Цэцэрлэг 1969.
10. Архангай аймгийн намын байгууллага, Цэцэрлэг 1973.
11. Архангай 60 жил, ред. Д.Товуу, Цэцэрлэг 1983.
12. *БНМАУ-н тэргүүний малчдын анхдугаар зөвлөгөөний их хурлаас гаргасан анхаарал бичиг.*

13. *Бүгд найрамдах монгол ард улсын орон нутгийн хоршооны нийтийн дүрэм.* Улаанбаатар 1948.
14. *Жижиг шинэ байгуулагдсан хоршоо эвлэлүүдийн орлого зарлага ба аж үйлдвэрийн төлөвлөгөөг хэрхэн үйлдэх заавар.* Улаанбаатар 1983.
15. *Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын Ардын зориг нэгдлийн түүхэн танилцуулга.* Мөрөн
16. Наваанлуvsан. *Хамтрал нь нэгдэлчдэд ямар ашиг өгмүй.* Улаанбаатар 1931.
17. *БНМАУ-ын тэргүүний малчдын анхдугаар зөвлөгөөний их хурлаас гаргасан анхаарал бичиг.* Улаанбаатар, 2014.
18. *Бүгд Найрамдах Монгол Ард Улсын орон нутгийн хоршооны нийтийн дүрэм.* Улаанбаатар 1938
19. *БНМАУ-ын эдийн засгийн үндсэн баялаг суурь болох нүүдлийн мал аж ахуйн нэгэн үйлдвэр болох хадлангийн станцуудын үйлдвэрийн өргөн зөвлөлгөөний хурлын эмхэтгэл тогтоол.* Улаанбаатар 1938.
20. *Бүх холбоотны Эв хамт намын 16-р хурал.* Улаанбаатар .
21. *Жасын мал хамтарч хариулах нөхдийн хоршооны дүрэм.* Улаанбаатар 1941.
22. Наваанлуvsан. *Хамтрал нь эмэгтэйчүүдэд ямар ашиг өгөв.* Улаанбаатар 1931.
23. *БНМАУ-ын ХАА-н нэгдэлчдийн III их хурлын материал.* Улаанбаатар: ХААЯ 1967.
24. *Худалдааны хоршоо байгуулах тухай дүрмийн төлөвлөгөө.* Улаанбаатар.
25. Л.Дорж. *Түүхэн замнал: Тосонцэнгэл сумын Ардын зориг нэгдлийн түүхэн танилцуулга.* Мөрөн: “Эрх чөлөө” сонины хэвлэх үйлдвэр 1990.
26. *БНМАУ-ын төрийн байгуулалт.* Улаанбаатар: СНЗ-ийн зохион зааварлах хэлтэс 1960.
27. *БНМАУ хөрөнгөтний биш хөгжлийн төлөө тэмцэлд.* Улаанбаатар: Улсын хэвлэл 1956.
28. Г.Цэрэнханд. *Нэгдэлч малчдын аж байдал.* Улаанбаатар: ШУА-ийн хэвлэл 1981.
29. *Нэгдэлчдийн тэмдэглэлийн дэвтэр.* Улаанбаатар: Улсын хэрэг эрхлэх хороо 1963.
30. Б.Санжаасүрэн, Б.Ринчин. *Нэгдлийн малчны лавлах.* Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар 1975.1990.

ХАВСРАЛТ. Хээрийн судалгааны ажлын үеийн гэрэл зургууд.



Эг-Үүрийн САА-н кино механикчаар ажиллаж байсан Мягмарсүрэнгийн байгуулсан музейд. Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сум.



2019 он. Баянхонгор аймгийн Баянлиг сумын “Ленинч” нэгдлийн нягтлан бодогч Баяраатай ярилцлага хийж байгаа нь.



2019. Архангай аймгийн
Ихтамир сумын “Гэрэлт зам”
нэгдлийн саальчин
Мөнгөнцэцэгтэй аман
түүхийн ярилцлага хийж
байгаа нь.



2019 он. Архангай аймгийн
Ихтамир сумын “Гэрэлт зам”
нэгдлийн малчин
Төмөрчөдөртэй аман
түүхийн ярилцлага хийж
байгаа нь.



2019 он. Хөвсгөл аймгийн
Тосонцэнгэл сумын “Ардын
зориг” нэгдлийн фермийн
дарга Батмөнхтэй аман
түүхийн ярилцлага хийж
байгаа нь.



2022 он. Архангай аймгийн
архивт баримт,
хөмрөгүүдтэй танилцах
орчин.

3.2. Төслийн судалгааны үр дүн

“Нэгдэлч малчдын түүхийг шинээр эргэн харахуй” суурь судалгааны төслийг хэрэгжүүлснээр “Сум нэгдлийн тогтолцоо (малчин өрх-нэгдэл-улс) ” 38,6.х.х. суурь судалгааны нэгэн сэдэвт зохиол, дотоод гадаадад 7 эрдэм шинжилгээний өгүүлэл хэвлүүлж, “Нэгдэлч малчдын түүхийг шинээр эргэн харахуй” эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулж, нэгдэлд гишүүн 35 ахмадаас ярилцлага авч аман түүхийн сан бүрдүүлэв. Төслийн судалгааны гол үр дүнг хүснэгтээр харуулбал:

№	Төслөөр бий болох үр дүн	Тоо хэмжээ	Үр дүнгийн биелэлт	
1	Хөдөө аж ахуйн нэгдэл нийгэм-эдийн засгийн хөгжилд гүйцэтгэсэн үүрэг, сургажлийг нэгтгэн дүгнэсэн “Нэгдэлч малчдын түүхийг эргэн харахуй (1960-1990 он)” суурь судалгааны бүтээл хэвлэгдэнэ.	15,х.х.	“СУМ-НЭГДЛИЙН ТОГТОЛЦОО (Малчин өрх-нэгдэл-сум)” суурь судалгааны нэгэн сэдэвт бүтээл хэвлэгдсэн. (38.6.х.х.)	“Сум нэгдлийн тогтолцоо” нэг сэдэвт хамтын бүтээлд зохиогчид БНМАУ-д оршин тогтнож байсан хөдөө аж ахуйн нэгдлийн 1960-1990 оны түүхийг эрх зүйн орчин, газрын болон мал аж ахуйн үйлдвэрлэлийн харилцаа, улсын бэлтгэлийн тогтолцоо, боловсрол, эрүүл мэнд, ажил эрхлэлт, шилжилт хөдөлгөөн, тэтгэвэр тэмгэмж зэрэг нийгмийн асуудлуудын үүднээс шинжлэн дүгнэсэн. (Нэгэн сэдэвт зохиолыг тайланд дагалдуулав)
2	Судалгааны үр дүнгээр гадаадын мэргэжлийн сэтгүүлд 2, дотоодын мэргэжлийн сэтгүүлд 5 өгүүлэл хэвлүүлнэ.	7 өгүүлэл /1 өгүүлэл хэвлэлтэд/	Дотоод 5 өгүүлэл	1 Н.Алтантөгс. ХААН-ийн мал аж ахуйн таваарын бүтээгдэхүүний борлуулалт, хэрэглээ. Historia Mongolarum. №537(39) 2019, т. 147-168.

				2	Р.Төрдалай. Монгол дахь хамтралжуулалт ба ЗХУ-ын нөлөөллийг эргэн харах нь. <i>Historia Mongolarum</i> . №537(39) 2019, т. 130-146
				3	Н.Алтантөгс, П.Дэлгэржаргал. БНМАУ-ын сум нэгдлийн тогтолцоо. <i>Historia Mongolarum</i> . №20(576) 2021, т. 5-18.
				4	Б.Чинзориг. Ардын аж ахуйтныг хоршоолсон нь (1958-1959): Түүх бичлэг ба бодит байдал. <i>Historia Mongolarum</i> . №20(576) 2021, т. 19-53
				5	Р.Төрдалай. Сум нэгдлийн газрын асуудал ба засаг захиргааны өөрчлөлт (1960-1990). №20(576) 2021, т. 54-69.
			Гадаад 2 өгүүлэл	6	“ <i>Soum negdel</i> ” <i>Agricultural and Administration System in Mongolia</i> . <i>Oriental Studies</i> . Scopus ID: 21100927989. 2023.
				7	Р.Төрдалай, “Влияние земельно-пастбищного отношения на территориально-административное деление в Монголии в процессе формирования сельскохозяйственных объединений (с 1935 года по 1959 год)”, <i>Научный журнал, Вестник, Калмыцкого института гуманитарных исследований РАН</i> , 2018.№ 2 (35)
3	Олон улсын эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах.	1 удаа	2021.11.26-нд “Нэгдэлч малчдын түүхийг шинээр эргэн харахуй” сэдэвт эрдэм шинжилгээний хурал зохион байгуулсан.	Төслийн баг Монголын Үндэсний музейтэй хамтран “Нэгдэлч малчдын түүхийг шинээр эргэн харах нь” сэдэвт эрдэм шинжилгээний хурлыг танхимаар болон онлайн хосолсон хэлбэрээр зохион байгуулсан бөгөөд хуралд Монгол улсаас 10, ХБНГУ-аас 1, АНУ-ын Индиана их сургуулиас 1 илтгэгч оролцож илтгэл хэлэлцүүлсэн. МУИС, Монголын Үндэсний музей, ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэн, Германы Гумбольдт их сургууль, АНУ-ын Индиана их сургуулийн судлаачид, мөн нэгдэлд хариуцлагатай ажил хийж байсан Б.Буянхишиг, Ү.Цэдэнбал, Н.Шомбодон зэрэг ахмад нэгдэлч, эдийн засагчид илтгэл хэлэлцүүлсэн болно.	
4	Нэгдлийн түүхтэй холбогдох олон төрлийн түүхэн баримт, анхдагч эх сурвалжуудыг системтэйгээр цуглуулж баримт-мэдээллийн сан бүрдүүлнэ.	1	Нэн шинэ үеийн түүхийн судалгааны эх сурвалжийн бааз суурийг өргөжүүлж, аман түүхийн сан үүсгэсэн.	Аман түүхийн сан бүрдүүлсэн. Үүнд Улаанбаатар, Архангай, Хөвсгөл, Баянхонгор зэрэг аймгийн 35 өндөр настантай ярилцлага хийж, дуу бичлэгийн нийт 40-иад цагийн ярилцлагын сан багтаж байна. Нэгдлийн аман түүхийн баримтыг нэгдлийн судалгааны бүтээл, өгүүлэл бичихэд өргөн хүрээгээр ашигласан бөгөөд судалгааны өндөр ач холбогдолтой юм. (CD-д бичиж хавсаргав)	

ДӨРӨВ. БҮТЭЭЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ

4.1. Нэгэн сэдэвт зохиолын тодорхойлолт

“Нэгдэлч малчдын түүхийг шинээр эргэн харахуй” суурь судалгааны төслийн хүрээнд бичсэн “Сум нэгдлийн тогтолцоо (Малчин өрх-нэгдэл-улс)” нэг сэдэвт хамтын бүтээлд зохиогчид БНМАУ-д оршин тогтнож байсан хөдөө аж ахуйн нэгдлийн 1960-1990 оны түүхийг эрх зүйн орчин, газрын харилцаа, нэгдлийн эдийн засаг, үйлдвэрлэлийн харилцаа, нийгмийн харилцааны үүднээс шинжлэн нэгтгэн дүгнэсэн бүтээл юм.

Тус бүтээлийн 1-р бүлэгт Монгол дахь ХАА-н хоршооллын хэлбэрүүд болох хамтрал, Ардын үйлдвэрлэлийн нэгдэл, ХААН-ын хөгжлийн үе шатыг тоймлон авч үзсэн. ХААН-ийг аж ахуй, зохион байгуулалтын хувьд бэхжүүлэх бодлого нь үнэн хэрэгтээ ардын аж ахуйтнуудыг ямар нэг байдлаар сайн дураар нэгдэлд элсэхээс өөр гарцгүй болгосон албадлага, захиргаадалтын арга хэмжээ авах бодлого байсан болохыг судлан дүгнэсэн. Нэгдэлжүүлэх хөдөлгөөн нь суурилан төрөөс засаг захиргааг өөрчлөн хувиргах, нийгмийн бүлэг давхрааг тэгшитгэх нийгэм-эдийн засгийн цогц шинэчлэл эхлүүлэх боломжийг бүрдүүлжээ. БНМАУ-д ХАА-н хоршооллын байгууллагын хөгжлийг дараах байдлаар үечлэх саналыг дэвшүүлж байна. Үүнд,

- Хамтрал, коммуны үе (1930-1932 он)
- Ардын үйлдвэрлэлийн нэгдлийн үе (1934-1954)
- Хөдөө аж ахуйн нэгдлийн үе (1955-1959)
- Сум-нэгдлийн үе (1959-1991) болно.

Тус бүтээлийн 2-р бүлэгт ХААН-ын эрх зүйн орчин, нам төрөөс нэгдлийн талаар явуулсан бодлогыг судлахад гол анхаарлаа хандуулсан болно. 1960-1990 оны хооронд БНМАУ-ын хөдөө орон нутагт оршин байсан “сум-нэгдэл” хэмээх захиргаа-аж ахуйн өвөрмөц тогтолцоог хөдөө аж ахуйн нэгдлийн малчдын амьдралыг судлах үндсэн аргачлал болгон авч, үүний үндсэн дээр сум-нэгдлийн эрх зүйн орчин, сум-нэгдлийн газрын харилцаан дахь малчид, сум-нэгдлийн үйлдвэрлэлийн харилцаа ба малчид, сум-нэгдлийн нийгмийн харилцааны асуудлуудыг шинжиллээ. 1963 оноос нэвтрүүлсэн “хөдөлмөр зохион байгуулалт, хөлсний тогтолцоо” нь мал аж ахуйн түүхий эдийн өртгийг бууруулах зарчимд үндэслэсэн тогтолцоо байсныг судлан тодруулсан, сум-нэгдлийн удирдлагын нэгдсэн тогтолцоо нь сум нэгдлийн даргад асар их эрх мэдлийг төвлөрүүлж, захиргааны аргаар нэгдлийг удирдах, мал аж ахуйн үйлдвэрлэлийг дээрээс шууд удирдах боломжийг олгож байсан гэсэн дүгнэлтэд хүрсэн болно.

Тус бүтээлийн 3-р бүлэгт нэгдлийн газрын асуудлыг сум-нэгдэл хэмээх ойлголттой нягт уялдуулах байдлаар судалж, сум-нэгдлийн бэлчээрийн болон бусад газар эзэмшлийн онцлог, түүний менежментийн асуудлыг авч үзэв. Сум-нэгдлийн тогтолцоогоор дамжуулж мал аж ахуйн хоршооллын байгууллага үйлдвэрлэлийн үндсэн хэрэгсэл болох бэлчээрийн газрыг Монголын түүхэнд анх удаа эзэмших болсон байна. Сум-нэгдлүүдийн эзэмшдэг бэлчээр нь улсын хэмжээний бэлчээрийн нөөц газрын ихэнхийг хамарчээ. Сум-нэгдлийн эзэмшил газарт зөвхөн бэлчээр төдийгүй, тариалангийн талбай, суурьшлын бүс, өвөлжөө, хаваржааны газар, гадаргын ус, ойн нөөц орж байлаа. Малчдын амьдралын үндэс болсон хөдөө аж ахуйн эдэлбэр газрыг улсын хэмжээнд бүгдийг нэгдэл болон сангийн аж ахуйнууд бүрнээр хуваан эзэмшиж байсны улмаас малчид нэгдлийн эзэмшил газар дээр сум-нэгдлийн тогтолцоогоор дамжуулан хөдөлгөөнгүй уягджээ.

Тус бүтээлийн 4-р бүлэгт сум-нэгдлийн систем дотор явагдаж байсан үйлдвэрлэлийн харилцааг авч үзэв. Ингэхдээ эн тэргүүн сум-нэгдлийн мал аж ахуйн үйлдвэрлэлийн хэрэгслийн ихэнхийг өмчлөгч нь бүх ард түмэн, харин эзэмшигч нь сум ба нэгдэл байсныг тодорхойлов. Үүний үндсэн дээр үйлдвэрлэлийн үндсэн үйл ажиллагааг нөхөн үйлдвэрлэл, үндсэн үйлдвэрлэл, бүтээгдэхүүн гаргалт гэсэн гурван үе шатаар тоймлож, төлөвлөгөө биелүүлсний урамшуулал нь эдийн засгийн хувьд ямар нэг үүрэг гүйцэтгэдэггүй байсныг олж илрүүлэв. Мөн үүний үндсэн дээр үйлдвэрлэлийг гардан эрхэлж байсан нэгдлийн малчдыг хөлсний ажилчдын ажлын хөлсний хэмжээ нь мал аж ахуйн таваарын өртгөөс

доогуур байгаа, нэмүү зөрүүг хөлсний ажилчин малчдын өмчилж байсан хувийн бяцхан аж ахуйн орлого нөхөж байсан талаар таамаглал дэвшүүлэв. Сум-нэгдлийн хэмжээнд бүтээгдэж байсан нэмүү өртөг нь тухайн орон нутагт материаллаг бүтээн байгуулалт болон өнөөг хүртэл үлдэж хоцорсон бөгөөд тэдгээр нь ихэнхдээ сум-нэгдлийн малчдын өөрсдийн бий болгосон хөдөлмөрийн хуримтлал юм гэдгийг тус бүлэгт тодорхойллоо.

Малчдын бий болгож байсан нэмүү өртөг нь зөвхөн орон нутгийн ач холбогдолтой биш юм. Тус бүтээлийн 5-р бүлэгт сум-нэгдлийн хэмжээнд бүтээгдэж байсан таваарын бүтээгдэхүүний дотроос хөдөө аж ахуйн нэгдлийн мал аж ахуйн таваарын бүтээгдэхүүнийг онцлон үзэж, түүний борлуулалт, хэрэглээг улсын бэлтгэлийн систем, аж үйлдвэрийн систем, гадаад худалдааны системд хайж илрүүлэв. Ингэснээр сум-нэгдлийн малчдын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн нь улсын бэлтгэлийн системд нийлүүлэгдэж, улсын бэлтгэлийн системээс дотоодын үйлдвэр ба гадаадад гаргах экспорт гэсэн үндсэн хоёр чиглэлд борлуулагдаж байсныг тодорхойлов. Сум-нэгдлийн малчдын бүтээсэн мал аж ахуйн бүтээгдэхүүн 1960-1970-аад оны үед ихэвчлэн ЗХУ руу гаргах экспортод зориулагдаж байсан бол 1970-80-аад онд бүтээгдэхүүний үндсэн урсгал өөрчлөгдөж, дотоодын аж үйлдвэрийн систем рүү хандах болсон томоохон өөрчлөлтийг тус бүлэгт голлон анхаарав. Ингэснээр малчдын бүтээсэн нэмүү өртөг нь зөвхөн орон нутгийн хөдөлмөрийн хуримтлал төдийгүй, улсын хэмжээний аж үйлдвэрийн салбарын хямд түүхий эдийн эх үүсвэр болж чадсаныг харуулахыг хичээв. Цаашид энэ өөрчлөлтийг тухайн үеийн үнийн бодлого, худалдааны нэмүү өртөг ба аж үйлдвэрийн нэмүү өртөгтэй уялдуулан судлах шаардлага бий.

Ингэснээр БНМАУ-д оршин байсан социалист үйлдвэрлэлийн харилцаа нь малчдын хүнд хэцүү, бага цалин бүхий хөдөлмөртэй салшгүй уялдаатайг тодорхойлсон судалгаа боллоо гэж бидний хувь үзэж байна.

Тус бүтээлийн 6-р бүлэгт нэгдэлч-малчдын нийгмийн асуудлыг хүн ам зүй, эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөрийн нөөц, хөдөлмөрийн харилцаа, тэтгэвэр тэтгэмж, гэмт хэргийн талаас тусгайлан судалсан. 1960-1990 оны хооронд явагдсан хүн амын дотоод шилжих хөдөлгөөний улмаас хот суурин газрын хүн ам хөдөөгийн хүн амаас гурав дахин хурдан өсөж байсан явдал эргээд сум-нэгдлийн хүн амын өсөлт буурахад хүргэсэн бөгөөд үүнээс үүдсэн хөдөлмөрийн нөөц хомсдол сум-нэгдлийн тулгамдсан болж байв.

Нэгдлийн үйлдвэрлэлийн тогтолцоо, түүний зохион байгуулалт, хатуу төлөвлөгөө, норм эргээд нэгдэлч малчдын эрүүл мэнд, боловсролд сөргөөр нөлөөлж байжээ. Нэгдлийн мал

аж ахуй дээр хөдөлмөр эрхэлж байгаа малчин ардын эрүүл мэндийн хамгаалал, хөдөлмөрийн хамгаалал хот суурин газраас хоцорч байсан тул 1970-аад оны дунд үеэс хөдөө орон нутгийн хүн амын нас баралт хот суурин газраас давав. Малчдын дундаж наслалт хот суурин газрын албан хаагч, үйлдвэрийн ажилчдаас бүр ч богиносжээ.

Сум, бригадуудад эмнэлгийн дэд бүтэц байгуулах, байгуулсан эмнэлэг, салбарт нэгдлийн гишүүдийг эмчлэх нь ямагт асар их зардалтай байв. Тиймээс төрөөс сум-нэгдлийн түвшинд эмнэлгийн асуудлыг хөдөө аж ахуйн нэгдлүүдийн хүч бололцоог бүхий л хэмжээгээр дайчилж байжээ. Хүүхэд асрах байр, төрөл бүрийн хүүхдийн цэцэрлэг, бага сургууль, дунд сургууль, сургуулийн дотуур байрыг нэгдлүүд өөрсдийн хүч бололцоогоор барьж байгуулж байсан бөгөөд эрүүл мэндийн салбартай адил, ардын боловсролын салбар, бүтэц хөдөө орон нутагт байгуулагдан оршиход хөдөө аж ахуйн нэгдлийн оруулсан хувь нэмэр их байв. Сум-нэгдлийн удирдлага ерөнхий боловсролын сургуулийн багш, сурагчдыг зүйл бүрээр дэмжин ажиллаж байв. Сурагчдын хөдөлмөрийн бригад, залуу малчны сургууль, илгээлтийн эздийн хөдөлгөөн зэрэг нам төрөөс ардын боловсролын талаар явуулж байсан бодлого хөдөө аж ахуйн нэгдлийн боловсон хүчнийг бэлтгэх, хангахад чиглэж байв.

Нэгдлийн үйлдвэрлэлийн тогтолцоо, түүний зохион байгуулалт, хөдөлмөрийн харилцаа нь малчдад хатуу төлөвлөгөө, нормыг төлөвлөх, биелүүлэхэд чиглэн зохиогдсон байжээ. Хөдөлмөрийн харилцаа, тэтгэвэр тэтгэмжийг судалснаар нэгдэлч малчдын амьдрал нийгмийн бусад давхарга, бүлгээс дорой, хатуу чанга байсан нь тодорхой харагдаж байна. Мөн нэгдлийн үйлдвэрлэлийн тогтолцоо нь гишүүн малчин хүнийг өөрт оногдсон төлөвлөгөө норм биелүүлэхээс өөр аргагүй гарцаагүй байдалд шахан оруулж байв. Сум-нэгдлийн тогтолцооны сул тал нь уг тогтолцоо малчин хүний төлөө байгаагүйд оршино. Сум-нэгдлийн бүтээгдэхүүний эцсийн хэрэглэгч нь улсын хилийн гадна байж, борлуулалтын зах зээл нь Монгол-Зөвлөлтийн эдийн засгийн интеграцид үндэслэж, малчдын бүтээсэн нэмүү өртөг малчдад бус, нийгмийн бусад давхаргад зориулагдаж байв.

4.2. Эрдэм шинжилгээний өгүүлэл

1.Н.Алтантөгс. ХААН-ийн мал аж ахуйн таваарын бүтээгдэхүүний борлуулалт, хэрэглээ. *Historia Mongolarum*. №537(39) 2019, т. 147-168.

БНМАУ-ын хөдөө аж ахуйн нэгдлийн таваарын бүтээгдэхүүний эцсийн хэрэглээнд 1960-1990 оны хооронд хувьсгалт гэмээр том өөрчлөлт гарсан байна. Хөдөө аж ахуйн нэгдлийн үндсэн зах зээл 1960-1990 онд шууд экспортоос дотоодын аж үйлдвэр болон жижиглэнгийн худалдаа рүү шилжжээ. 1980-аад он гэхэд хөдөө аж ахуйн нэгдлүүд мал аж ахуйн таваарын бүтээгдэхүүнээ улсын бэлтгэлд тушааж, улсын бэлтгэлд бүрдсэн тэрхүү нөөцөөс дотоодын мах комбинатууд, хувцас, арьс ширний үйлдвэрүүдэд ихэнхийг нийлүүлж, тэдгээрээр үйлдвэрүүдэд эцсийн бүтээгдэхүүн буюу хагас боловсруулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэж, зарим бүтээгдэхүүнийхээ бараг ихэнхийг тэр чигээр нь экспортод гаргадаг тогтолцоо БНМАУ-ын социалист эдийн засагт бүрдээд байв. Хөдөө аж ахуйн нэгдлүүд таваар үйлдвэрлэгч хэлбэрээр оршин тогтнох үндсэн хүчин зүйл бол Зөвлөлт-Монголын эдийн засгийн интеграци байсан гэсэн дүгнэлтэд хүрэв.

2. Р.Төрдалай. Монгол дахь хамтралжуулалт ба ЗХУ-ын нөлөөллийг эргэн харах нь. *Historia Mongolarum*. №537(39) 2019, т. 130-146

Энэхүү өгүүлэлд 1930-аад оны Монголын хөдөө аж ахуйн хөгжилд Зөвлөлт Оросын үзүүлсэн бодит нөлөөллийг архивын баримтад түшин залгамж холбоонд нь тусган авч үзэхийг зорисон. Ингэснээр хамтралжуулалт нь үнэн хэрэгтээ Монголын эдийн засгийн түүхэнд дэх “зөвлөлтжүүлэх бодлого”-ын үр хөврөл байсан эсэх талаарх судлаачийн байр суурийг илэрхийлэхийг чухалчилсан болно. Эх сурвалж баримтуудаас үзэхэд хамтралжуулалтаар дамжин Монгол оронд хоршоолох үйл явц эхлэлээ тавьсан хэдий боловч “зөвлөлтжүүлэх бодлого” өрнөж, их гүрний улс төрийн шахалтаар уг үйл явц хэрэгжсэн хэмээн үздэг уламжлалт дүгнэлтийг эргэн харах шаардлагатай болж байна. Өөрөөр хэлбэл, Зөвлөлт Орос улсаас Монгол оронд хэрэгжүүлсэн бодлого, үйл ажиллагаа нь тус улсад нөлөөний хүрээгээ баттай хадгалах чиглэлд түлхүү хэрэгжсэн гэж үзэхэд хүргэж байна.

3. Н.Алтантөгс, П.Дэлгэржаргал. БНМАУ-ын сум нэгдлийн тогтолцоо. *Historia Mongolarum*. №20(576) 2021, т. 5-18.

Энэхүү өгүүлэлд 1960-1992 онд оршин тогтнож байсан сум-нэгдэл нь газар нутаг, хүн ам, удирдлагын нэгдсэн тогтолцоо бүхий захиргаа-аж ахуйн тогтолцоо байсныг судлан шинжилсэн. Захиргаа-аж ахуйн хосолмол бүтэц бүхий сум-нэгдлийн тогтолцоо нь захиргааны эрх мэдлээ мал аж ахуйн үйлдвэрлэлд хэрэглэх эрхтэй сум нэгдлийн даргад асар их эрх мэдэл төвлөрүүлж, “захиргаадалтын” дэглэмийг бэхжүүлж өгсөн байна. Удирдлагын

энэ тогтолцоо нь мал аж ахуйн үйлдвэрлэлийг захиргааны аргаар удирдаж, нөөцийг дээд зэргээр дайчлан улсын төлөвлөгөөг биелүүлэх боломжийг нэгдэлд олгож байсныг тодруулав. 1963 оноос нэвтрүүлсэн хөдөлмөр зохион байгуулалт, хөлс төлөлтийн тогтолцоо нь хөдөлмөрийн нөөцийг дайчлах, мал аж ахуйн бүтээгдэхүүний өөрийн өртгийг бууруулах, бүтээгдэхүүний гарцыг нэмэгдүүлэх зарчимд суурилж байсныг судлан тодруулав.

4. Б.Чинзориг. Ардын аж ахуйтныг хоршоолсон нь (1958-1959): Түүх бичлэг ба бодит байдал. *Historia Mongolarum*. №20(576) 2021, т. 19-53

Архивын баримтаас үзэхэд, Архангай аймгийн ардын аж ахуйтнууд нэгдэлжих хөдөлгөөнийг нэлээд эсэргүүцсэн бөгөөд тэдний эсэргүүцэл 1959 оны МАХН-ын ТХ-ны III бүгд хуралд Ю.Цэдэнбалын дэвшүүлсэн мал дахин нийгэмчлэх бодлого тунхаглагдсаны дараа улам хурцадсан байна. Нэгдэлжүүлэх хөдөлгөөн бүхэлдээ “сайн дурын” үндэн дээр явагдаагүй болохыг архивын баримт болон аман түүхийн мэдээ хангалттай нотолж байна. Эсэргүүцэл байсан хэдий ч суртын бригадууд аядуу тайван, албадлага шахалтын аргыг аль алиныг нь хослуулан хэрэглэж, сайтар төлөвлөсөн, зохион байгуулалттай үйл ажиллагаа явуулснаар ардын аж ахуйтныг богино хугацаанд нэгдэлд олноор нь элсүүлж чадсан ажээ.

5. Р.Төрдалай. Сум нэгдлийн газрын асуудал ба засаг захиргааны өөрчлөлт (1960-1990). *Historia Mongolarum*. №20(576) 2021, т. 54-69.

1960-аад оны үед олон сумдыг хооронд нь нэгтгэж нийлүүлэхдээ зөвхөн хуучин хилийн заагийг арилгах байдлаар газар нутгийг эзэмшүүлж, сум-нэгдлүүдийн цаашдын хэтийн төлөв, хөгжлийн асуудалд эдийн засгийн үүднээс судалгаа хийж, газар нутгийг олгоогүйгээс зарим сум-нэгдэл бэлчээрийн хомсдолд орох нөхцөл үүссэн байна. 1971 онд БНМАУ-ын газар эдэлбэрийн хууль батлагдсанаар газрын эрхийн асуудлыг сум-нэгдэл буюу орон нутгийн удирдлагаас төвд шилжүүлж, суурин болон нүүдлийн гэсэн газрын харилцааны холимог хэв маяг зэрэгцэн орших болсон. 1971 оны БНМАУ-ын газар эдэлбэрийн хуулийн онцлог нь газрыг эдэлбэрт олгох асуудлыг улам бүр төвлөрүүлж, орон нутаг буюу аймаг, сум, хорооны АДХГЗ-ны эрх мэдлийг зохих хэмжээнд хязгаарласанд оршиж байна. Үүний улмаас сум-нэгдэл нь улсаас тогтоосон эзэмшил газрын тухайд эрх ашиг нь зөрчигдсөн тохиолдолд өөрийн өмнө тулгамдсан асуудлыг бие даан шийдвэрлэх чадамжаар сул болсонд оршино. Үүнийг гэрчлэх архивын баримтууд цөөнгүй байгаа нь ч

эрхгүй анхаарал татаж байна. Сум-нэгдлийн дарга нар эзэмшил нутгийнхаа хүрээнд газрын харилцааны олон талт асуудлыг хариуцан зохицуулагч нь байв.

6. “Soum negdel” Agricultural and Administration System in Mongolia. *Oriental Studies*. Scopus ID: 21100927989. 2023.

In this article, we aim to take a holistic view of the relationships between *soums* and *negdels* and make some suggestions about their main role in a centrally planned economy of Mongolia. It is impossible to separate the administrative and economic structures, where the territory and the subordinate population overlapped, and the executive role of the *soum-negdel* in the socialist society is complex and unified wholly. Creating a part of the socialist accumulation from animal husbandry, necessary for the construction of a communist society, is the main function of a *soum-negdel* can be considered. The *soum-negdel* is a method of transforming the cooperative from the whole community into a tenant of land by giving all the people’s land to a specific cooperative for free and for an indefinite period. In turn for free and indefinite land usership, the *negdel* assumed a duty for all people to be a socialist enterprise and to fight against the origin of private property. The *negdel* had gained an economic benefit by employing the *soum* laborers cheaply since according to the constitution, the *negdel* was an enterprise that had a monopoly right to use the pastoral land of the *soum*. The chief of the *soum-negdel* - the dual governmental activity was a political and economic method to strengthen the *negdel* foundation and produce the largest number of livestock products at the lowest possible cost. The *soum-negdel* was running full authority to manage the quantity of the supply of pastoral livestock products by political and economic compulsion. Furthermore, *negdels* become different from the previous laborer’s manufacturing cooperatives because socialist cooperatives were existing in the *soum-negdel* system and lost the cooperatively characteristics too. Therefore, it is not optimal to consider the *negdel*, which was existing within the *soum-negdel*, as a cooperative, because they are different from the previous and present cooperative forms in quality. Additionally, from the historical perspective, *soum-negdel* can be a single object, and it was a unique system of administration and economy.

7. Turdalai Radnaased. Mongolian’s Administrative Division during the Formation of Agricultural Associations (1935-1959): the Impact of Land and Pasture Issues. *Oriental Studies*, 2019. Is. 2. pp. 184-194.

The goal of the article is to consider the impact of land and pasture issues on peculiarities of formation of the agricultural cooperatives in 1935–1959 concerning the administrative-territorial division. Results. The co-existence of private and state cooperative property resulting from the emergence and development of agricultural cooperatives that had a certain impact on land-pasture relations in the MPR gave rise to a number of essential issues and difficulties. State and cooperative organizations, such as agricultural cooperatives, state enterprises, machine-tractor stations, farmer cooperatives, finally required detailed regulations for land-pasture relations to be accompanied by a reorganization of the territorial-administrative division of the MPR. That proved the biggest reorganization in the history of Mongolia from 1950 to 1960, and the country was administratively divided into 1568 bags, 330 soums and 21 aimags. The wealth creation, land exploitation and pasture policy for the 255 agricultural cooperatives, 17 joint cooperative enterprises, 9 joint cooperatives and 90 state enterprises that had existed until 1990 played the key role in the situation. Conclusion. Land-pasture relations as the basis for cattle breeding were drastically changed in the MPR during the formation of agricultural cooperatives and in the post-liquidation period. However, the land as common amenities was within the jurisdiction of the state, which governed land matters and the system of agricultural cooperatives.

ТАВ. СУДАЛГААНЫ ШИНЭЛЭГ ТАЛ

Монголын мал аж ахуйн түүхэнд анх удаа XX зууны дунд үед малыг нийгэмчилж “хоршоолсон” нь олон мянганаар уламжилж ирсэн малчдын амьдралын тогтсон зохион байгуулалтыг өөрчилж, мал аж ахуйн үйлдвэрлэлд чанарын шинэчлэл гаргасан томоохон үйл явдал байсан билээ. Нэгдлийн түүхийг малчин өрх - нэгдэл - улс гэсэн гурван түвшинд судалгааны шинэлэг арга зүйгээр судалж, социализмын үеийн нэгдлийн түүхийг нэгтгэн дүгнэх нь одоогийн мал аж ахуйн цаашдын хөгжлийн арга замыг тодорхойлоход чухал ач холбогдолтой юм. “Сум-нэгдлийн тогтолцоо (малчин өрх-нэгдэл-улс)” нэгэн сэдэвт зохиолын гол зорилго нь социализмын үеийн нэгдэл болон нэгдлийн гишүүн малчдын түүхийг бүхэлд нь нэгтгэн дүгнэж, ХААН-ийн Монголын нийгэм, эдийн засаг, соёлын хөгжилд гүйцэтгэсэн үүргийг тодорхойлоход оршино. Уг нэгэн сэдэвт зохиол дараах асуудлыг шинээр авч үзэхийг оролдсон болно. Үүнд:

- Нам, төрөөс нэгдлийг хөгжүүлэх талаар явуулсан бодлогод дүн шинжилгээ хийж, 1960-1992 онд оршин тогтнож байсан сум-нэгдэл нь газар нутаг, хүн ам, удирдлагын нэгдсэн тогтолцоо бүхий захиргаа-аж ахуйн тогтолцоо байсныг тодруулсан,

- Захиргаа-аж ахуйн хосолмол бүтэц бүхий сум-нэгдлийн тогтолцоо нь захиргааны эрх мэдлээ мал аж ахуйн үйлдвэрлэлд хэрэглэх эрхтэй сум нэгдлийн даргад асар их эрх мэдэл төвлөрүүлж, “захиргаадалтын” дэглэмийг бэхжүүлж өгсөн байна. Удирдлагын энэ тогтолцоо нь мал аж ахуйн үйлдвэрлэлийг захиргааны аргаар удирдаж, нөөцийг дээд зэргээр дайчлан улсын төлөвлөгөөг биелүүлэх боломжийг нэгдэлд олгож байсныг шинжлэн судалсан,

- 1963 оноос нэвтрүүлсэн хөдөлмөр зохион байгуулалт, хөлс төлөлтийн тогтолцоо нь хөдөлмөрийн нөөцийг дайчлах, мал аж ахуйн бүтээгдэхүүний хив өөрийн өртгийг бууруулах, бүтээгдэхүүний гарцыг нэмэгдүүлэх зарчимд суурилж байсныг судлан тодруулсан,

- 1960-аад оноос сум-нэгдлийн газрын харилцааны эрх зүйн үндэс бүрэлдсэн тухайд анхааран судалж, 1960-1990 онд хамаарах сум-нэгдлийн газрын харилцааны зохицуулалт, газар эзэмшлийн онцлог, хэлбэрүүд, нэгдэлч малчдын газар ашиглалт, сум-нэгдлийн тогтолцооны үеийн газрын маргаан, түүнийг хэрхэн шийдвэрлэж байсан асуудлыг түүхэн баримтад тулгуурлан тодотгон зураглахыг чармайсан,

- Малчин өрхийн түвшинд сум-нэгдлийн мал аж ахуйн үйлдвэрлэлийн хөдөлмөр зохион байгуулалт, нэгдэлч малчин өрхийн орлого, зарлага, өрхийн амьжиргаанд амины малын гүйцэтгэж байсан үүргийг тодруулсан,

- Нэгдлийн түвшин дэх судалгаагаар нэгдлийн орлого ба зарлагын бүтцийг судалж, ХААН нь аж ахуйн нэгжийн хувьд хэр үр ашигтай тогтолцоо байсныг тодруулсан. Түүнчлэн мал аж ахуйн бүтээгдэхүүнийг бэлтгэн нийлүүлэх тогтолцоог судалсан,

- Судалгааг улсын ба бүс нутгийн түвшинд авч үзэхдээ сум-нэгдэл бүр улсын төвлөрсөн төлөвлөгөө, улсын бэлтгэлийн тогтолцоогоор дамжуулан Зөвлөлтийн Транссибирийн төмөр замтай нягт интеграцид орсныг тодруулсан,

- Нэгдлүүд нь сургууль, эмнэлэг, цэцэрлэг, улаан булан, халуун усны газар зэрэг соёл ахуйн барилга байгууламжуудыг өөрийн хөрөнгөөр барьж байгуулах зэргээр хөдөөгийн хөгжилд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэсэн явдлыг шинжилсэн,

- Нэгдлийн түүхтэй холбоотой баримт бичиг, тоон мэдээлэл бүрдүүлэхэд анхаарч, түүхэн тоон аргыг хэрэглэхийн зэрэгцээ нэгдэлч малчдын боловсрол, соёл, эрүүл мэнд зэрэг нийгмийн өдөр тутмын амьдралын өөрчлөлтийн түүхийг тодруулахдаа аман түүхийн мэдээ баримтыг өргөн ашигласан, зэрэг болно.

ЗУРГАА. НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН АЧ ХОЛБОГДОЛ

Монголын нүүдлийн мал аж ахуйн хөгжлийн цаашдын бодлого боловсруулах, төлөв байдлыг тодорхойлоход шаарлагатай судалгааны үндсэн суурь бүрэлдэхэд энэхүү судалгаа нь суурь хэрэглэгдэхүүн болно. XX зуунд социализм байгуулах бодлогын хүрээнд хийгдсэн нэгдэлжүүлэх үйл явцын эдийн засгийн үр ашиг, хөдөлмөр зохион байгуулалт, бэлчээрийн менежмент, өвс тэжээл, худаг усаар хангах тогтолцоо, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг бэлтгэн нийлүүлэх тогтолцоо, мал сүргийг эрүүлжүүлэх, малчдын соёл, боловсрол, эрүүл мэндийн асуудал зэрэг өнөөгийн малчдын өмнө ч тулгарсаар байгаа багц асуудлыг тухайн үед хэрхэн шийдсэн арга зам, алдаа оноог дүгнэх замаар өнөөгийн Монголын мал аж ахуйн хөгжилд тулгарч буй бэрхшээлийг шийдэх гарц олоход энэхүү судалгаа чухал ач холбогдолтой.

Түүнчлэн, XX зууны нэгдэлжүүлэх үйл явц өнөөгийн Монголын хөдөө аж ахуйн төрх байдал, хэв шинж бүрэлдэхэд хэрхэн нөлөөлсөн хийгээд цаашид Монголын мал аж ахуйн хөгжлийн оновчтой бүтэц, тогтолцоог бүрэлдүүлэхэд энэ талын судалгаанаас нэмэрлэж болох дүгнэлт гаргалгааг санал болгон хуваалцах, энэ чиглэлд түүх, антропологийн судалгааны шинэ арга зүйн хандлагыг нэвтрүүлэхэд хувь нэмэр болно.

Нэгдлийн гишүүн малчин байсан хүмүүсээс ярилцлага, сурвалжлага авах зэргээр аман түүхийн мэдээг дуу, дүрсээр бичиж авч үлдэх нь энэ судалгаанд төдийгүй ирээдүйн судалгааны материал болж хадгалагдан үлдэнэ.

Нэгдлийн түүхийг **малчин өрх- нэгдэл - улс** гэсэн гурван түвшинд түүх-антропологийн судалгааны арга зүйгээр судалж, нэгтгэн дүгнэж, улмаар одоогийн мал аж ахуй, малчдын талаар төрөөс явуулах бодлого боловсруулахад шаардлагатай судалгааны үнэлэлт дүгнэлт, тоо баримт, статистикийн судалгааны материалын нөөц бүрдэнэ.

Бид өнөөгийн Монголын мал аж ахуйд тулгарч буй малын тоо толгойн хэт өсөлт, бэлчээрийн даац хэтрэлт, борлуулалтын сүлжээний дутагдал зэрэг тулгамдсан асуудлыг шинжлэх ухааны үндэстэй шийдвэрлэхийн тулд, эн тэргүүнд сум-нэгдлийн тогтолцооны туршлагыг, түүхий эдийн борлуулалтын зах зээлийг малчны хоттой холбож байсан улсын бэлтгэлийн тогтолцоог, нэгдлийн түүхийг эргэн харж, туршлага сургамжийг авч ашиглахад “Сум нэгдлийн тогтолцоо” бүтээл нь чухал ач холбогдолтой хэмээн үзэж байна. Энэ бол

бидний туулж өнгөрүүлсэн түүх, Монголын асуудлыг монгол онолоор шийдэх хөрс суурь билээ.

ХАВСРАЛТ